



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

149 /149/

2021.10.05

## ОЛОН УЛСЫН БАТШ НАРЫН БАЯРЫН МЭНД ХҮРТЭЭ!

### МЭНДЧИЛГЭЭ



Эх орноо батлан хамгаалах эрхэм хүндтэй үйл хэргийг гардан хэрэгжүүлэгч үндэсний шилдэг сэхээтнүүд, цэргийн гарамгай жанжид, чадварлаг мэргэжилтнүүд, үе үеийн эх орончдыг сургаж бэлтгэсэн 100 жилийн баялаг түүхтэй Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн удирдлага, эрдэмтэн докторууд, хүндэт профессорууд, эрдэм шинжилгээний ажилтнууд, багш судлаачид Та бүхэндээ Дэлхийн багш нарын болон Монголын багш нарын өдрийн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Төв азийн тэгш өндөрлөгт хэдэн зуун мянган жилээр оршин аж төрөхдөө Монголчууд эрдэм мэдлэгийг эрхэмлэн хүндэтгэж, түүнд төгсөрсөн билэг оюун төгөлдөр хүмүүнийг ямагт хүндэтгэн дээдэлж, түүнийг агуулан түгээгч бичиг шастирыг алт эрдэнэ, торго дурдан зэрэг аль тансаг төрүүтнээр баринтаглан хадгалж, үеийн үедээ өв уламжлуулан нандингаж ирсэн ард түмэн билээ.

Байгаль, нийгмийн тоо томшгүй олон ухааны язгуур үндэс, мөн чанарыг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ГҮРСЭДИЙН САЙХАНБАЯР

монголчууд эртнээс нааш судалж, танин мэдэж, үйл ажиллагаандаа үр дүнтэйгээр хэрэглэж ирсэн нь мэдлэг гэдэг бол зөвхөн мэдэхийн нэр биш, түүнийгээ ашиглаж, үр шимийг нь зөв хүртэхийн нэр гэдгийг ухаарсны баталгаа юм.

Монголчуудын үр хүүхдээ хүмүүжүүлж, боловсруулж ирсэн өвөрмөц нэгэн арга барил бол гэрийн боловсролын тогтолцоо юм. Улс гэрийнхээ төрийг засаж, гадаад ертөнцтэй оновчтой харилцаж, төр, улсаа үеийн үед төвшитгөж ирсэн олон хаад, ноёд, цэргийн жанжид, түшмэдүүд бүгд л гэрийн боловсрол эзэмшиж, алсыг харсан төрийн хүний холч мэргэн ухаанд төгс боловсорсон олон жишээг бид мэднэ.

Энэ мэт үндэснийхээ дэвшилтэт үзэл санаа, сургаал, өвөрмөц онцлогийг сургалт, хүмүүжлийнхээ үйл ажиллагааны үндэс суурь болгож, түүнд суурилсан орчин үеийн сургалтын технологи, арга зүйг ул суурьтай нэвтрүүлэхийг эрмэлзэх нь Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш хэмээн хүндэтгэн дуудуулах Таны үйл ажиллагааны эрхэм чухал үнэт зүйл байх учиртай.

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш судлаачид, суралцагчдын сургалт, эрдэм шинжилгээ, инновацын гүйцэтгэл, тэдгээрийн үр дүнд тодорхой ахиц дэвшил гарч, аюулгүй байдал, батлан хамгаалах судлалаар үндэсний хэмжээнд тэргүүлэх, бүс нутагтаа өрсөлдөх чадвартай болох эрхэм зорилго, стратегийн зорилтуудаа хэрэгжүүлэхэд ихээхэн амжилт гаргаж байгаад Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн өмнөөс болон хувиасаа талархаж байгаагаа илэрхийлэхэд таатай байна.

Домог түүхтэй их сургуулийнхаа үе үеийн эрдэмтэн, багш, сурган хүмүүжүүлэгч Та бүхэндээ багш нарын өдрийн баярын мэндийг дахин дэвшүүлж, сургалт, эрдэм шинжилгээ, хүмүүжлийн ариун үйлсэд нь их амжилтыг хүсэн ерөөе.

### Үйл явдал

## ТЭНГЭР ГАЗАРТ НИЖИГНЭСЭН СҮРТ БУУДЛАГАТАЙ "СЭЛЭНГЭ-2021" ХААЛТАА ХИЙЛЭЭ

"Сэлэнгэ-2021" байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль 9 дүгээр сарын 22-ноос 10 дугаар сарын 5-ныг хүртэлх хугацаанд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хээрийн сургалтын төвийн газар, районд амжилттай зохион байгуулагдлаа.

Дугаар шилжих энэ цаг мөчид "Сэлэнгэ 2021" хээрийн сургуулийн хаалтын ёслолын арга хэмжээ Төв аймгийн Зуунмод хотноо болж байна.

Өнгөрсөн жил явагдсан "Сэлэнгэ-2020" сургуулийн тухайд гэвэл дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдлаас үүдэж хоёр орон тус тусдаа ижил цаг хугацаанд явагдаж байсан бол энэ жил Монгол, Орос дайчид өмнөх жилүүдийн уламжлалыг сэргээж нэгэн удирдлага дор нэгдэн хамтдаа үүрэг гүйцэтгэсэнээр онцлог байлаа. Энэ удаагийн "Сэлэнгэ-2021" хээрийн сургууль "Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд бэлтгэх, зохион байгуулах нь" сэдвийн хүрээнд амжилттай явагдсан бөгөөд Монголын талаас сургуулийн удирдагчаар Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, ОХУ-ын талаас Дорнод цэргийн тойргийн 36 дугаар армийн командлагчийн үүрэг гүйцэтгэгч, хошууч генерал И.Б.Тимофеев нар ажилласан юм.

Тус сургууль гурван үе шаттайгаар явагдлаа. Тодруулбал, ОХУ-ын цэрэг дайчдыг сургалт, дадлагад оролцох зэвсэг, техникийн хамт хүлээн авахаас эхлээд хуурай болон 25, 50 хувийн сум, галт хэрэгсэлтэйгээр буудлагын дадлага хийж эцэст энэ сарын 4-ний өдөр буюу өчигдөр гол үйл ажиллагаа болох байлдааны буудлагаар үргэлжилсэн юм. "Сэлэнгэ-2021" сургуулийн үйл ажиллагаатай Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, ОХУ-аас Монгол

Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Искандер Кубарович Азизов, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, УИХ-ын гишүүн, АБГБХ-ны дарга Б.Баттөмөр, УИХ-ын гишүүн Н.Энхболд, Д.Цогтбаатар, ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Херш орнуудын газрын дэд захирал Б.Болор болон албаны бусад хүмүүс сургуулийн буудлагын үйл явцтай танилцсан юм. Монгол Улсын Ерөнхий сайд Э.Оюун-Эрдэнэ нэгдсэн байлдааны буудлагын дараа нийт алба хаагчдад хандаж хэлсэн үгэндээ "Монгол, ОХУ-ын дипломат харилцаа тогтоосны болон орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой тохиож буй энэ цаг мөчид "Сэлэнгэ-2021" хээрийн Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж буй нь олон ач холбогдлыг дагуулж байна. Өнгөрсөн нэгэн зууны хугацаанд Монгол, Оросын Зэвсэгт хүчин дайны хүнд жилүүдийг хамтдаа даван туулж энх цагийн бүтээн байгуулалтад оролцож явсныг түүх гэрчилнэ. Энэхүү хамтарсан хээрийн сургууль нь манай хоёр орон итгэмжит найрамдалт харилцааны нэг хэлбэр болсоор ирсний зэрэгцээ болзошгүй терроризмын аюул заналхийлэхэд сөрөг үйл ажиллагаанд бэлтгэх чадварыг ахиулахад ихээхэн нөлөө үзүүлдэг гэдэгт итгэл дүүрэн байна. Цаашид хоёр орны цэргийн хамтын ажиллагаа улам бэхжиж, хамтарсан сургууль дадлагад оролцож харилцан туршлага солилцох боломж илүү нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна" гээд



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 306.828 +1501	ЭДГЭРСЭН 353.086 +6239	НАС БАРСАН 1274 +14
-----------------------------------	---------------------------	------------------------

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5373 +90	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 187	ЭДГЭРСЭН 5081
-----------------------------	----------------------------	------------------

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 236,130,997
Эдгэрсэн Нийт: 213,179,853
Нас барсан Нийт: 4,822,154

### Түүхэнд энэ өдөр

1917 он:

Хатанбаатар С.Магсаржавын цэрэг Сэцэн хан аймгийн Сүжигт вангийн хошууны Дархан уул орчимд хятад цэрэгтэй байлджээ

1923 он:

Цэргийн эмнэлгийн харьяанд амбулатори байгуулах тухай Засгийн газрын шийдвэр гарчээ.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
11	-1

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	22

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,851.00
EUR	3,316,0	3,325,0
CNY	441,3	442,0
RUB	38,60	40,30
JPY	25,35	25,93
KRW	2,32	2,44

### ЗУРХАЙ

2021.10.05 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 29/

ХАРЦАГА ОДТОЙ, УЛААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

Наран ургах, шингих:  
06.57-18.24

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал:

Мод

Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Эрдэнийг гадагш өгөх, нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одоогод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



## БЭЛЭН БАЙДАЛТАЙ ТАНИЛЦЛАА



ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Материал техникийн газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр тэргүүтэй албаны хүмүүс ажиллалаа.

Энэ үеэр бригадын генерал С.Дашзэвэг "Өнөөдөр бид НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх гурван салбарын бэлтгэл ажлыг шалгаж байна. Тус байгууллагаас манай оронд алба ёсоор үнэлгээний баг хүрэлцэн ирэх ёстой байсан ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хойшилсон учир хоёрдугаар шатлалын үнэлгээ гаргах үйл ажиллагааг энэ сарын 5-20-ны хооронд цахим хэлбэрээр зохион байгуулна. Үүний дараа гуравдугаар шатлалын үнэлгээг мөн адил цахим хэлбэрээр явуулахаар төлөвлөөд байна" гэв.

Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн багийн бэлэн байдлыг НҮБ-аас дөрвөн шатлалаар үнэлж, үүрэг гүйцэтгэх чадавхыг тодорхойлдог. Монгол Улсын Зэвсэгт хүчнээс энхийг дэмжих ажиллагаанд оролцох барилга-инженерийн рот 2017 онд, хоёрдугаар шатны хээрийн эмнэлэг 2019 онд, түргэн байрлах хүчний рот 2020 онд тус бүр нэгдүгээр

шатлалын болзлыг хангасан байдаг. Тэгвэл өнгөрсөн Бямба гаргт дээрх гурван салбарын бүрэлдэхүүний хоёрдугаар шатлалын үнэлгээнд орох бэлэн байдлыг шалгах үйл ажиллагаа Зэвсэгт хүчний 350, 337 дугаар ангид зохион байгуулагдлаа. Тус үйл ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай,

## СУМЫН ЗАСАГ ДАРГА НАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

### Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Засгийн газрын 2018 оны 376 дугаар тогтоолоор батлагдсан "Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журам"-ын холбогдох заалтыг үндэслэн 24 сумын Засаг дарга нарт "Орон нутгийн хамгаалалт, орон нутгийн цэргийг зохион байгуулах, удирдах" сэдэвт цэргийн бэлтгэл сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Улам-Оргих, аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Үнэнбаяр нар оролцов.



Сургалтын үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал урилгаар оролцож "Олон улсын аюулгүй байдлын орчин, цэрэг-улс төрийн байдал" сэдвээр илтгэл тавьснаараа онцлог байлаа.

Хошууч Г.БАВУУДОРЖ

## "Сэлэнгэ 2021" байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн буудлагын үйл явц гэрэл зурагчны дуранд



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ